



## СҮРЬЕЭ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн байх /хамт олны хурлын тэмдэглэл хавсаргах/;
2. Сүрьеэгийн мэргэшлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг хэрхэн гүйцэтгэсэн талаар тайлагнах, шинэ туршлага нэвтрүүлсэн байх;
3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлсэн, мэргэжлийн сэтгүүлд хураангуй болон өгүүлэл хамтран бичиж хэвлүүлсэн байх /баримтуудыг хавсаргах/;
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод гадаадад мэргэшлийн сургалтад хамрагдсан байх;
5. Сүүлийн 5 жилд тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил жилээр нь багцлан хавсаргах/;

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачлагатай гүйцэтгэж ирсэн, хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн байх /хамт олны хурлын тэмдэглэл хавсаргах /;
2. Сүрьеэгийн мэргэшлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг өөрөө гүйцэтгэхийн зэрэгцээ залуу эмч нарт зааж сургасан байх, шинэ туршлага нэвтрүүлсэн байх;
3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, онол практикийн хуралд илтгэл хэлэлцүүлсэн, мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл бичиж хэвлүүлсэн байх /баримт хавсаргах/;
4. Сүрьеэгийн чиглэлээр эмч мэргэжилтнийг дагалдуулан сургасан байх /холбогдох баримт, тушаал хавсаргах/;

5. Сүүлийн 5 жилд тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх /гэрчилгээ болон сургалтанд хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил жилээр нь багцлан хавсаргах/.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачлагатай, манлайлан гүйцэтгэж ирсэн, салбартаа нэр хүндтэй хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн байх /хамт олны хурлын тэмдэглэл/;
2. Сүрьеэгийн мэргэшлийн тусламж үйлчилгээнд зайлшгүй гардан хийх үйлдлийг залуу эмч нарт зааж сургасан байх, шинэ туршлага нэвтрүүлсэн байх, мэргэжлийн түвшинд зөвлөх, бие даан мэргэжлийн санал дүгнэлт гаргаж ирсэн, үнэлгээнд багийн ахлагч эсвэл гишүүнээр ажилласан бодлогын баримт бичиг боловсруулахад биечлэн оролцсон байх /холбогдох баримтууд, тушаалыг хавсаргах/;
3. Өөрийн нэрээр гаргасан бүтээлийн жагсаалт гаргасан байх, тухайн бүтээлүүд нь мэргэжлийн сэтгүүлүүд дээр хэвлэгдсэн байх, ажилдаа нэвтрүүлсэн байх /баримтуудыг эх хувиар нь хавсаргах /;
4. Тухайн мэргэжлийн чиглэлээр эмч мэргэжилтнийг дагалдуулан сургаж, мэргэжлийг нь дээшлүүлсэн байх /холбогдох баримт, тушаалыг хавсаргах/;
5. Өөрийн ажилласан хугацааны ажлын тайлан, туршлагыг нэгтгэн бичиж, байгууллагын удирдлага хамт олноор баталгаажуулсан байх.